



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 2/44

Амардалай

Худалдаа үйлчилгээний газрын цагийн хуваарьт  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуй нэгжүүд сар бүрийн 1, 15, 25 ны өдрүүдэд архи, согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглож, бусад өдрүүдэд аж ахуй нэгж байгууллагын ажиллах цагийн хуваарийг 08:00-21:00 цагийн хооронд шилжүүлсүгэй.

2. Ард иргэдэд үйлчлэх тав тухтай орчныг бүрдүүлж, хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг тогтмол ханган өөрийн байгууллагын гадна, дотно орчныг сайжруулж, нийтийг хамарсан их цэвэрлэгээний үед худалдаа үйлчилгээ явуулахыг түр хугацаагаар зогсоож, өөрийн аж ахуй нэгжийн ойр орчмоос 50 метр хүртэлх талбайг 7 хоног бүр цэвэрлэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Б.Азжаргал), Хэсгийн цагдаа (Б.Ууганбаатар), Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн (Б.Баттогтох) нарт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/73 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ